



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/192/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2025 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Ари файнэнс аудит ХХК-ийн Захирал: Д.Ариунаа Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
5. Аудитын илрүүлэлт	18
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУЯ	Боловсрол шинжлэх ухааны яам
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ШУ	Шинжлэх ухаан
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НА	Нотлох ажил



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР
СУМЫН 6 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.ОДГЭРЭЛ ТАНАА

2025.02.25 № 00А-2025/192/НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлын онцолсон хэсэг

Тус цэцэрлэг нь 2024 онд хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор “Хашаа” төсөл, хүүхэд хүлээн авах өрөөний “Шидэт шилэн гонх” төслийг орон нутгийн хөрөнгө оруулалтаар 31,300.0 мянган төгрөгөөр хийж гүйцэтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

432502273

Бусад асуудлын хэсэг

Тус цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 39 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 92.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	76,563,672.43	120,542,877.45
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	56,153,492.63	75,455,194.47
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	56,153,492.63	75,455,194.47
3121	Төгрөг	56,153,492.63	75,455,194.47
31211	Төрийн сангийн харилцах	56,153,492.63	75,455,194.47
35	БАРАА МАТЕРИАЛ	20,410,179.80	45,087,682.98
351	Түүхий эд материал	2,345,064.80	2,461,503.04
35130	Эм боох материал	2,345,064.80	2,461,503.04
354	Хангамжийн материал	18,065,115.00	42,626,179.94
35420	Аж ахуйн материал	6,757,165.00	10,257,965.00
35460	Хүнсний материал	885,850.00	1,637,995.00
35470	Бусад хангамжийн материал	10,422,100.00	30,730,219.94
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	53,721,218.41	304,461,281.30
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	53,721,218.41	304,461,281.30
392	Биет хөрөнгө	53,346,218.27	304,336,281.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	244,396,362.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(3,033,636.51)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	46,224,986.47	51,778,486.47
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,288,111.06)	(28,080,391.11)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	34,232,509.20	37,664,309.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,876,166.34)	(12,504,465.59)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	14,374,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(311,383.34)
39217	Ном	53,000.00	53,000.00
393	Биет бус хөрөнгө	375,000.14	125,000.18
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(874,999.86)	(1,124,999.82)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	130,284,890.84	425,004,158.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	130,284,890.84	425,004,158.75
51	Засгийн газрын хувь оролцоо	130,284,890.84	425,004,158.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	8,104,590.00	8,104,590.00
51101	Өмч: - төрийн	8,104,590.00	8,104,590.00
512	Хуримтлагдсан үр дүн	122,180,300.84	416,899,568.75
51210	Өмнөх үеийн үр дүн	122,180,300.84	122,180,300.84
51220	Тайлант үеийн үр дүн	-	294,719,267.91
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	130,284,890.84	425,004,158.75

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	289,016,046.35	741,939,389.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,858,660.00	289,120,681.94
120	Нийтлэг татварын бус орлого	41,858,660.00	289,120,681.94
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,993,000.00	90,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,993,000.00	90,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31,605,360.00	267,755,662.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	5,260,300.00	21,275,019.94
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	247,157,386.35	452,818,707.21
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	210,465,200.00	417,063,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	210,465,200.00	417,063,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,692,186.35	35,755,507.21
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,692,186.35	35,755,507.21
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	318,230,816.75	447,220,121.24
21	УРСГАЛ ЗАРДАЛ	318,230,816.75	447,220,121.24
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	318,230,816.75	447,220,121.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,302,880.93	318,150,056.24
210101	Үндсэн цалин	163,017,339.78	230,090,145.76
210102	Нэмэгдэл	42,036,708.30	81,790,280.48
210104	Урамшуулал	4,248,832.85	6,269,630.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,410,288.35	40,407,839.42
210201	Тэтгэврийн даатгал	18,292,839.90	28,140,280.11
210202	Тэтгэмжийн даатгал	2,152,098.79	3,310,621.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,682,079.03	1,609,110.64
210204	Ажилгүйдлийн даатгал	380,250.17	1,469,565.52
210205	Эрүүл мэндийн даатгал	3,903,020.46	5,878,262.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,631,316.35	25,933,397.21
210301	Гэрэл, цахилгаан	4,144,606.35	5,132,797.21
210302	Түлш, халаалт	14,177,280.00	17,280,490.00
210303	Цэвэр, бохир ус	2,309,430.00	3,520,110.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,844,790.00	-
210408	Бараа материал акталсны зардал	1,844,790.00	-
2105	Нормативт зардал	23,916,823.50	27,485,004.50
210502	Хоол, хүнс	23,916,823.50	27,485,004.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,060,870.00	9,822,110.00
210604	Урсгал засвар	16,060,870.00	9,822,110.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	565,000.00	978,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	565,000.00	978,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,498,847.62	24,443,713.87
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,173,218.84	5,461,214.76
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,578,300.00	1,966,900.00

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	10,747,328.78	17,015,599.11
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(29,214,770.40)	294,719,267.91
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(29,214,770.40)	294,719,267.91

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	252,150,386.35	452,908,707.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,993,000.00	90,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,993,000.00	90,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,993,000.00	90,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,993,000.00	90,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	247,157,386.35	452,818,707.21
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	210,465,200.00	417,063,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	210,465,200.00	417,063,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	36,692,186.35	35,755,507.21
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	36,692,186.35	35,755,507.21
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	306,579,128.13	433,607,005.37
21	УРСГАЛ ЗАРДАЛ	306,579,128.13	433,607,005.37
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	306,579,128.13	433,607,005.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,302,880.93	318,150,056.24
210101	Үндсэн цалин	163,017,339.78	230,090,145.76
210102	Нэмэгдэл	42,036,708.30	81,790,280.48
210104	Урамшуулал	4,248,832.85	6,269,630.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,410,288.35	40,407,839.42
210201	Тэтгэврийн даатгал	18,292,839.90	28,140,280.11
210202	Тэтгэмжийн даатгал	2,152,098.79	3,310,621.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,682,079.03	1,609,110.64
210204	Ажилгүйдлийн даатгал	380,250.17	1,469,565.52
210205	Эрүүл мэндийн даатгал	3,903,020.46	5,878,262.04
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,631,316.35	25,933,397.21
210301	Гэрэл, цахилгаан	4,144,606.35	5,132,797.21
210302	Түлш, халаалт	14,177,280.00	17,280,490.00
210303	Цэвэр, бохир ус	2,309,430.00	3,520,110.00
2105	Нормативт зардал	24,590,572.50	28,237,149.50
210502	Хоол, хүнс	24,590,572.50	28,237,149.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,060,870.00	9,822,110.00
210604	Урсгал засвар	16,060,870.00	9,822,110.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	565,000.00	330,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	565,000.00	330,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,018,200.00	10,726,453.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,136,700.00	8,171,643.00

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,881,500.00	2,554,810.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(54,428,741.78)	19,301,701.84
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,993,000.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,993,000.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	4,993,000.00	-
222001	Тоног төхөөрөмж	4,993,000.00	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(4,993,000.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(59,421,741.78)	19,301,701.84
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		56,153,492.63
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	56,153,492.63	75,455,194.47

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Төгрөгөөр/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,104,590.00	151,395,071.24	159,499,661.24
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,104,590.00	151,395,071.24	159,499,661.24
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	(29,214,770.40)	(29,214,770.40)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,104,590.00	122,180,300.84	130,284,890.84
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,104,590.00	122,180,300.84	130,284,890.84
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,104,590.00	122,180,300.84	130,284,890.84
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	294,719,267.91	294,719,267.91
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,104,590.00	416,899,568.75	425,004,158.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	516,643,500.00	433,607,005.37	83,036,494.63	83.9
21	УРСГАЛ ЗАРДАЛ	516,643,500.00	433,607,005.37	83,036,494.63	83.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	516,643,500.00	433,607,005.37	83,036,494.63	83.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	377,634,000.00	318,150,056.24	59,483,943.76	84.2
210101	Үндсэн цалин	260,790,400.00	230,090,145.76	30,700,254.24	88.2
210102	Нэмэгдэл	112,544,700.00	81,790,280.48	30,754,419.52	72.7
210104	Урамшуулал	4,298,900.00	6,269,630.00	(1,970,730.00)	145.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45,076,100.00	40,407,839.42	4,668,260.58	89.6
210201	Тэтгэврийн даатгал	30,652,300.00	28,140,280.11	2,512,019.89	91.8
210202	Тэтгэмжийн даатгал	3,605,600.00	3,310,621.11	294,978.89	91.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,803,000.00	1,609,110.64	193,889.36	89.2
210204	Ажилгүйдлийн даатгал	1,803,000.00	1,469,565.52	333,434.48	81.5
210205	Эрүүл мэндийн даатгал	7,212,200.00	5,878,262.04	1,333,937.96	81.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	33,336,900.00	25,933,397.21	7,403,502.79	77.8
210301	Гэрэл, цахилгаан	9,476,200.00	5,132,797.21	4,343,402.79	54.2
210302	Түлш, халаалт	16,138,700.00	17,280,490.00	(1,141,790.00)	107.1
210303	Цэвэр, бохир ус	7,722,000.00	3,520,110.00	4,201,890.00	45.6
2105	Нормативт зардал	35,505,800.00	28,237,149.50	7,268,650.50	79.5
210502	Хоол, хүнс	35,505,800.00	28,237,149.50	7,268,650.50	79.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.00	9,822,110.00	177,890.00	98.2
210604	Урсгал засвар	10,000,000.00	9,822,110.00	177,890.00	98.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,253,700.00	330,000.00	923,700.00	26.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,253,700.00	330,000.00	923,700.00	26.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,837,000.00	10,726,453.00	3,110,547.00	77.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,295,000.00	8,171,643.00	2,123,357.00	79.4
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,542,000.00	2,554,810.00	987,190.00	72.1
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	516,643,500.00	452,908,707.21	63,734,792.79	87.7

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	417,063,200.00	417,063,200.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	417,063,200.00	417,063,200.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	43,336,900.00	35,755,507.21	7,581,392.79	82.5
132001	Орон нутгийн төсвөөс	43,336,900.00	35,755,507.21	7,581,392.79	82.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	56,243,400.00	90,000.00	56,153,400.00	0.2
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	90,000.00	90,000.00	-	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	56,153,400.00	-	56,153,400.00	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		56,153,492.63	(56,153,492.63)	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		75,455,194.47	(75,455,194.47)	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	18	17	1.00	94.4
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	9	9	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	8	7	1.00	87.5
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	50	53	(3.00)	106.0
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	50	53	(3.00)	106.0
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	50	53	(3.00)	106.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18	17	1.00	94.4
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	8	8	-	100.0
650007	Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ)	1	1	-	100.0
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	1	1	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	7	1.00	87.5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар сумын 6 дугаар цэцэрлэг нь *“Бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэхэд оршино”* гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлсэн байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд цэцэрлэгтээ айдасгүй, амар тайван суралцаж, суралцахуйн хоцрогдолгүйгээр эрүүл, аюулгүй, тэгш хүртээмжтэй орчинд сурч хөгжих боломжийг бүрдүүлэх
- Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан тасралтгүй хөгжих олон хувилбарт сургалт үйл ажиллагааг зохион байгуулж менежментийг сайжруулах
- Багш ажилтан бүр ёс зүйн хэм хэмжээ шаардлагыг мөрдөж, төсвийг төлөвлөх үр ашигтай зарцуулахад идэвх санаачилгатай оролцох

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор “Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 05 сарын 29 өдрийн 237 дугаар тогтоолоор цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон;*
- *Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг *аккруэл* сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсвийн төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй, шинээр гарсан хууль тогтоомж, дүрэм, журмын өөрчлөлтийг тусгах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 294,719.2 мянган төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	56,153.5	75,455.2	19,311.7
Бараа материал	20,410.2	45,087.7	24,677.5
Үндсэн хөрөнгө	53,721.2	304,461.3	250,740.1
Нийт хөрөнгө	130,284.9	425,004.1	294,719.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	130,284.9	425,004.1	294,719.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	130,284.9	425,004.1	294,719.2

Дээрх хүснэгтээс харахад, нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 75,455.2 мянган төгрөг болж 19,311.7 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материалын дансны үлдэгдэл 45,087.7 мянган төгрөг болж 24,677.5 мянган төгрөгөөр өссөн нь аймгийн Боловсролын газраас 17,600.0 мянган төгрөгийн стем хэрэглэгдэхүүн, Японы хүүхдийн ивээх сангаас 2,310.0 мянган төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй авч бараа материалын дансанд бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 304,461.3 мянган төгрөг болж 250,740.1 мянган төгрөгөөр өссөн нь сумын ИТХ-ын 2024 оны 09-р сарын 23-ны өдрийн 185 дугаар тогтоолоор 220,117.3 мянган төгрөгийн цэцэрлэгийн барилгыг үнэ төлбөргүй шилжүүлэн авсан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор “Хашаа” төслөөр 11,500.0 мянган төгрөгийн хашаа, “Шидэт шилэн гонх” төслийг хэрэгжүүлж 19,800.0 мянган төгрөгийн хүүхэд хүлээн авах өрөө, Японы хүүхдийн ивээх сангаас 8,785.3 мянган төгрөгийн компьютер, принтер зэрэг үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авч бүртгэсэн нь голлон нөлөөлсөн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус цэцэрлэгийн 2024 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 368,115.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 38,236.9 мянган төгрөгөөр, нийт 406,352.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналаас улсын төсвийн санхүүжилтийг 54,047.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 460,400.1 мянган төгрөгөөр баталснаас тайлант онд төсөвт зохицуулалт хийгдэж улсын төсвөөс 417,063.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 43,336.9 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 90.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 56,153.4 мянган төгрөг, **нийт 516,643.5 мянган төгрөгөөр** баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 417,063.2 мянган төгрөгийг, орон нутгийн төсвөөс 35,755.5 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 90.0 мянган төгрөг зэрэг нийт 452,908.7 мянган төгрөг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаанд 433,607.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 433,607.0 мянган төгрөг буюу 83.9 хувьтай байгаа нь боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 67,455.3 мянган төгрөгөөр, цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 7,268.7 төгрөгөөр хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт хувиар
	Улсын төсвөөс санхүүжих				
1	80233-Хүүхэд хамгаалал	582.2	582.2	0.0	100.0
2	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,194.0	1,145.0	49.0	99.7
3	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	35,505.8	28,237.1	7,268.7	79.5
4	81816-Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	2,111.3	2,093.9	17.4	99.2
5	81823-Боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	1,034.7	370.0	664.7	35.7
6	81834-Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх	432,788.6	365,333.3	67,455.3	84.4
7	83603-Нэмэлт -Дээд шатны төсвөөс хуваарилсан	90.0	90.0		100.0
	Дүн	473,306.6	397,851.5	75,455.1	84.0
	Орон нутгийн төсвөөс				
8	8011-Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал	43,336.9	35,755.5	7,581.4	82.5
	Дүн	43,336.9	35,755.5	7,581.4	82.5
	Нийт дүн	516,643.5	433,607.0	83,036.5	83.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайланг худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулан хоол хүнсний 28,844.0 мянган төгрөгийн бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтыг 1 удаа зарласан боловч оролцогч ирээгүйгээс Алтан тариа ХХК, Цахим ертөнц ХХК, иргэн Б.Байгалмаа, Н.Болор-Эрдэнэ,

Н.Цэрэнлхам, С.Төмөрбаатар, Т.Уранчимэг, Ц.Сайханчимэг нартай тус тус шууд гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “Ари фاینэнс аудит” ХХК-ийн аудитор Б.Туяа гүйцэтгэж, захирал Д.Ариунаа анхан шатны чанарын хяналтыг, Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ари фاینэнс аудит” ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 318,230.8 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,773.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сүхбаатар сумын 6 цэцэрлэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,

- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус цэцэрлэг нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 173 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус цэцэрлэгийн 2024 оны 2 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3		3		100.0
Нийт дүн	3		3		100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой дараах 13.1 мянган төгрөгийн алдааг залрууллаа. Үүнд:

- Үр дүнгийн тайланд 13.1 мянган төгрөгийн хоолны зардлыг дутуу тайлагнасан

Аудитаар нийт 2,764.5 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчлийг давтан гаргахгүй ажиллах 1 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хөрөнгийн бүртгэлтэй холбоотой асуудал

1.1 **Илрүүлэлт:** Эцэг эхчүүдээс хүүхдийн сургалт, эрүүл ахуйн хэрэгцээнд үнэ төлбөргүй өгсөн 2,764.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна..

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1-д “аж ахуйн бүх ажил, гүйлгээ”, 14.4.5-д “бүх орлого” гэсэн заалтыг зөрчсөн байна.

1.2 **Өгсөн зөвлөмж:** Үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг бүртгэлд бүрэн тусгаж, зарцуулалтад хяналт тавьж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр дүнгийн тайланд хоолны зардлыг дутуу тайлагнасан	1	13.1			1	13.1	1	13.1				

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

**Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын 6 дугаар цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Дүн	1	13.1			1	13.1	1	13.1				
------------	----------	------	--	--	----------	------	----------	------	--	--	--	--

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийг бүртгэлд тусгаагүй	1	2,764.5					1	2,764.5				
Дүн	1	2,764.5					1	2,764.5				